

“GEN Z” ҮЕИЙН ЦЭРГИЙН АЛБА ХААГЧДИЙН СЭТГЭЛ ЗҮЙН ОНЦЛОГИЙГ СУДАЛСАН НЬ

Э.Пүрэвжав

ДХИС-ийн Удирдлагын академийн 8012 дугаар дамжааны суралцагч, хошууч

Товч агуулга: Хил хамгаалах байгууллагад хугацаат цэргийн алба хаахаар татагдан ирж буй хугацаат цэргийн албан хаагчдын сэтгэл зүйн онцлогийг судлан тэдэнтэй ажиллах арга барилын талаар дүгнэлт, санал дэвшүүлэх.

Abstract: Studying the psychological characteristics of conscripts coming to serve in the border guard organization and making conclusions and suggestions about the way to work with them.

Түлхүүр үгс: Z үе, хугацаат цэргийн алба хаагч, сэтгэл зүйн онцлог.

Keywords: Generation Z, conscripts, psychological characteristics

Оршил

Ойролцоогоор нэг цагт төрсөн, ижил үйл явдлыг туулсан хүмүүс ямар төстэй байдаг вэ? Үүнийг үеийн онол тайлбарлах гэж оролддог.

X, Y, Z, онолууд Хүний мөн чанарын тухай үзлийг 1960-аад онд АНУ-ын эрдэмтэн Дуглас Макгрегорийн боловсруулсныг X ба Y онолын цогц нэгдлээр илэрхийлж болно.

Тэрээр удирдагч хүн өөрийн удирдлагад байгаа хүмүүстэйгээ харилцахдаа тэдний хөдөлмөрт хандах хандлагыг ямар байдлаар төсөөлж өөрсдийн үүргээ хэрхэн ойлгодгийг тодорхойлсон X ба Y гэсэн хоёр онолыг дэвшүүлсэн юм.¹

Нэг. Үеийн онол, түүний тухай ерөнхий ойлголт

Үеийн онол нь янз бүрийн үеүүд яагаад гарч ирдэг, тэдгээрийг юу нэгтгэдэг, хэрхэн өөрчлөгдөж байгааг тодорхойлдог судалгааны арга юм.

Оросын

Боловсролын

Академийн Сэтгэл судлалын хүрээлэнгийн эрдэмтэд орчин үеийн ахлах сургуулийн сурагчид өөрсдийгөө болон эцэг эхийнхээ үеийнхээс юугаараа ялгаатай болохыг илрүүлэхийн тулд 1989-2019 оны Оросын өсвөр насныхны хоёр үеийг харьцуулсан томоохон судалгаа хийжээ.²

Тус хүрээлэнгийн захирал Павел Сергомановын тайлбарласнаар “X, Y, Z” үеүдийн тухай тусдаа онол байхгүй. 1854 оноос эхлэн АНУ-д хийгдсэн судалгааг 1991 онд Уильям Стросс, Нейл Хоу нар урагш ахиулж, тухайн түүхэн үе үеийнхний ерөнхий онолын зөвхөн нэг хэсгийг тусгасан бөгөөд эдийн засаг, нийгэм, технологийн даяарчлал нь энэхүү онолыг олон улс оронд түгээхэд хүргэсэн байна. Шинжлэх ухааны үүднээс нарийвчлан авч үзвэл энэ нь үе үеийн онолын асуудлын дүн шинжилгээ гэхээсээ илүү түүхэн

¹ <https://www.buro247.mn/lifestyle/expert/z-eiykhniy-talaar-bid-yuug-medekh-kheregtey-ve.html>

² <https://updown.mn/203693.html>

бодол эргэцүүлэл, түүхэн үе үеийн технологи, орчны технологийн тухай” асуудал юм хэмээн Сергоманов тайлбарлажээ.¹

Үүний зэрэгцээ, “Х, Ү, Z” үеийн онолд хүмүүсийн танин мэдэхүйн чадвар, сэтгэл хөдлөл, үнэ цэнэ, өөрийгөө үнэлэх үнэлэмж, хамаарлын түвшин хэрхэн өөрчлөгдөж байгааг нотлох баримт байхгүй. **Сергоманов:** “Өнөөдөр огт өөр насны хүмүүс (20 настай, 40 настай, 60 настай, тэр ч байтугай түүнээс дээш насныхан) хайлтын систем ашиглах, мессенжерээр чатлах, стрим үзэх зэрэг ижил ур чадвар, дадал зуршлыг хурдан эзэмшиж байна. Гар утасны тусламжтайгаар хүссэн хүнтэйгээ шууд холбогдох боломжтой. Энэ бүхэн маш өндөр настай хүмүүсийн өдөр тутмын амьдралын ердийн нэг хэсэг болсон” гэж онцлон тэмдэглэв. Эрдэмтэд ийм ерөнхий болон өнгөц шинж чанарууд нь тухайн улс орны амьдралын тодорхой нөхцөлд өсөж бий болсон үеийнхний хоорондох бодит ялгааны талаар ойлголт өгөх боломжгүй гэж үзжээ.

“Бидний судалгаа нь түүхийн харьцуулсан судалгааны төрөлд хамаарах бөгөөд энэ нь янз бүрийн түүхэн эрин үе дэх соёл, нийгэм-сэтгэл зүйн үзэгдлийн өөрчлөлтийг тогтоох боломжийг олгодог. Энэхүү хандлага нь судалгааны стратеги, арга, шинжлэх ухааны зарчмуудын тасралтгүй байдлыг илэрхийлдэг бөгөөд энэ нь олж авсан эмпирик материалын өндөр найдвартай байдлыг баталгаажуулдаг” хэмээн Андреева тэмдэглэжээ.

Түүхэн үе бүр дэх өсвөр насныхны сэтгэл зүй, нийгмийн

төлөвшилийг тогтоохын тулд тухайн хүний нас биед хүрсэн үе, ирээдүйн бие даасан амьдралын чиг хандлага, хүсэл эрмэлзэл, боломжийн талаарх санаа бодлыг тусгасан хувь хүний хөгжлийн параметруудийг сонгон судлах шаардлагатай ажээ. Эрдэмтэд өмнөх болон орчин цагийн өсвөр насныхны хоорондох хамгийн том ялгаа нь хариуцлагын параметрт илэрдэг болохыг тэмдэглэж байна. Үүнээс гадна судалгаанд оролцогчдын 40 гаруй хувь нь одоо цагаараа амьдрахыг илүүд үзэж байна. Энэ нь орчин үеийн олон судлаачдын тэмдэглэсэн “өсвөр насны үргэлжлэх хугацаа уртсах хандлагатай” байгаатай нийцэж буй бололтой.

Х үе (1960-1980 оныхон):

Энэ үе бол дэлхийн 2-р дайны дараах үеийн бүтээн босголтыг бий болгосон гэр бүлд өссөн үеийнхэн. Тэдний эцэг эх маш их хөдөлмөрлөж, гэр бүлдээ анхаарал хандуулах цаг бага байсан учир энэ үеийн хүүхдүүд бие даасан, насанд хүрсэн хойноо зөвхөн өөртөө л найддаг. Эдийн засаг, улс төрийн олон өөрчлөлтүүд энэ үеийнхэнд тохиолдож, тэдний тусламжтайгаар шинэ нийгмийг дахин бүтээсэн. Энэ үеийнхэн нуран унасан тогтолцооны тэнцвэрийг хадгалахын тулд байнга дасан зохицож, ёс суртахууны асар их хүч чармайлт гаргах шаардлагатай байв.

Ү үе (1980-2000-аад оныхон) шинэ мянганыхан:

Энэ үеийнхийг Х үеийнхэн өсгөж хүмүүжүүлсэн. Эцэг эх өөрсдөө мэдрээгүй анхаарал хайр халамжийг тэдэнд өгч, амьдралын чухал салбар, карьерын сонголт хийх хүртэлх бүх боломжийг тэдэнд өгсөн.

¹ <https://updown.mn/203693.html>

Ү үеийнхэн өөрөө өөрийнхөө төлөө хариуцлага хүлээх боломжтой өссөн тул тэд оройтож хүүхэд гаргасан. Тэдний өсөж хөгжих явцад мэдээллийн өргөн орчин бий болж, амьдрал бодит болон виртуал хэмээн хуваагджээ.

Z үе (2000-2010 оныхон):

Энэ үеийг эцэг эхчүүд төдийгүй нөлөө бүхий хүмүүс өсгөсөн. Үүнээс болж тэд өөрсдийн үйлдлүүдийг хүрээлэн буй орчноос ирсэн санал хүсэлт, хариу үйлдэл дээр үндэслэн нийтлэлийн доорх хариу сэтгэгдлээр өөрийгөө үнэлдэг.

Чухал сэдвээр үзэл бодлоо илэрхийлэхдээ маш болгоомжтой ханддаг. Тэд юуг ч энгийн зүйл гэж үздэггүй хэдий ч олон үзэл бодол, хэт их мэдээллийн орчинд дүн шинжилгээ хийх шаардлагатай болсон ч тэдэнд цаг хугацаа хангалттай биш. Тэд маш хурдтай ертөнцөд өсөж түүний хэмнэлд дассан. Энэ үеийнхний нийтлэг шинж бол олон нийтийн сүлжээнд дуртай, маш товч мэдээллийг илүүд үздэг байна.

Зетистүүд ихэнх мэдлэгээ вебээс авдаг тул бодит амьдралын туршлагаас нэлээд хөндий, үргэлж шинэ мэдрэмжийг эрэлхийлдэг.

Альфа үе (2010-аад оноос өнөөг хүртэл):

Энэ үе одоог хүртэл бүрэлдэж байна. Хүүхдэд хэт хатуу хандах хандлага нь хоцрогдсон тул альфа үеийнхэн эцэг эхийнхээ ноёрхлыг мэдэрдэггүй, насанд хүрэгчидтэй ижил түвшинд харьцдаг; Тэд багаасаа л виртуал орон зайд хамаг цагаа өнгөрөөдөг тул өдөр тутмын амьдралдаа салан задгай байдалтай.

Тэднийг баярлуулах маш хэцүү, учир нь тэдэнд хоол хүнс, хувцас хунар, тоглоом наадгай гээд маш олон төрлийн зүйл хангалттай байна.¹

1.1. Z үеийнхний онцлог

Gen Z буюу шинэ үеийнхэн гэж хэн бэ?

Ихэнх сурвалжуудын тодорхойлсноор олон улсад Z үеийнхэн хэмээх ойлголтод ерөнхийд нь 1995-1997 оноос 2010-2015 оны хооронд төрсөн буюу ойролцоогоор 10-25 настай залуусыг хамааруулж ойлгодог. Улс орон бүрийн туулж өнгөрүүлсэн түүх, нийгмийн байдал харилцан адилгүй тул үеэр ангилах ангилал 2-5 жилийн хооронд хэлбэлзэх нь бий.²

Монгол Улсад:

Монгол улсын жишээн дээр хийгдсэн "Монголын нийгмийн үеийг тодорхойлох судалгаа" 2020 онд гарсан. Уг судалгааны тайланд Монголын нийгмийн үеүдийг дараах байдлаар ангилсан байна:


- Социалист үеийнхэн (1964 оныг хүртэл)
- Завсрын үеийнхэн (1965-1982 оны хооронд)
- Шилжилтийн үеийнхэн (1983-1994 оны хооронд)
- Шинэ үеийнхэн (1995 оноос хойш)

Дээрх тайланд Шинэ үеийнхнийг (Z үе) тодорхойлохдоо: "Хувь хүний эрх чөлөөний мэдрэмж өндөртэй, либерал үзэлтэй, төр болон намд итгэдэггүй, институтэд биш өөртөө илүү итгэдэг, бусад үеүдтэй харьцуулахад хамгийн их дижитал, сошиал хэрэглээтэй байна. Тэд бусад үеүдтэй харьцуулахад үзэл бодлын

¹ <http://mongolcom.mn/read/14027>

² <https://unread.today/c/random-genz-entertainment>

хувьд илүү баруунжсан, глобалчлагдсан байна." гэжээ.



Зураг 1. Нийгмийн үе

Gen Z буюу шинэ үеийнхний онцлог

- Нэгэн зэрэг олон ажил хийх чадвар:

Z үеийнхний хувьд компьютер дээр юм хийнгээ, утсаа оролдох, подкаст сонсох гэх мэт эдгээр зүйлсийг зэрэг хийх нь энгийн үзэгдэл. Үүнийг дагаад **сөрөг тал нь нэг зүйл дээр анхаарлаа удаан төвлөрүүлэх чадвар тааруу** байдаг. Тасралтгүй шинэчлэгдэж өөрчлөгдөж буй техник технологийн үед амьдарч байгаа учраас тэдний анхаарал төвлөрүүлэх хугацаа нь өмнөх үеүдээс бага байдаг. Гэсэн хэдий ч мэдээллийг боловсруулахдаа хурдан байдаг.

- Багаар ажиллахаас илүү бие даах чадварыг чухалчилдаг

Судалгаанд хамрагдсан нийт Z-үүдийн 71 хувь нь “Хэрвээ чи зөв

хийхийг хүсэж байвал зөвхөн өөрийнхөөрөө хийх хэрэгтэй” гэсэн агуулга бүхий хариултыг өгчээ. Тэд сэтгэлгээний хувьд өөртөө эзэн байх, хувийн ур чадвар, бие хүний төлөвшлөө дээшлүүлэх болон өрсөлдөөнд маш идэвхтэй байдаг. Харин ажлын байран дээрх Z-үүдийн 69 хувь нь хамт олонтойгоо бус ганцаараа нэг өрөөнд ажиллахыг илүүд үздэг бөгөөд багаар ажиллахаас илүүтэй бие даан шийдвэр гаргахыг илүүд үздэг байна.

- Хүчээр далайлгадаг удирдлагуудтай ажиллахыг хүсдэггүй

Нэгэн судалгаанд оролцсон Z үеийнхэн удирдлагуудын “Coach” буюу Чиглүүлэгч хийх ур чадварыг “чухал гэж 75 хувь” нь, “маш чухал гэж 25 хувь” нь үзжээ. Хэрэв байгууллагын удирдлагууд нь

ажилчдаа айдас түгшүүрт автуулж удирддаг бол дөрвөн Z үе тутмын нэг нь ажлаа орхино гэжээ.

Хугацаат цэргийн албанд татагдан ирж буй залуусын онцлог

Хугацаат цэргийн албанд өнөөгийн байдлаар 2000-2005 оны залуучууд буюу Z үеийнхэн татагдан ирж байна.

Тэд,
хүний эрхийн мэдрэмж өндөртэй,

(Дүрмийн бус харьцаа, доромжлолыг тэвчдэггүй, энэ талаар социологийн судалгаа, ганцаарчилсан уулзалт, бүлгийн уулзалтаар нууж, хаалгүй ярьдаг)

шударга бус байдлыг хүлээн зөвшөөрдөггүй,

(офицер, ахлагч болоод хугацаат цэргийн алба хаагчдын ялгаа заагт тийм ч таатай ханддаггүй, цэрэг бол адилхан л хүн, цэргийг адилхан хүн гэдэг байдлаар хараасай гэж хүсдэг)

бүгдэд адилхан эрх тэгш хандахыг шаарддаг,

(Жишээ нь, харуул хамгаалалтад үүрэг гүйцэтгээд амрах ёстой байсан бол ижил хугацаанд адил амралт эдлэхийг хүсдэг, хэн нэгэнд илүү хандахад шүүмжлэх байр суурь илэрхийлдэг),

өөрсөдтэй нь чөлөөтэй харьцаж, үзэл бодлыг нь сонсохыг хүсдэг,

(Сэтгэл зүйн дэмжлэг шаарддаг, өөрсөдтэй нь хурц, чанга, илт загинаж зандарсан, албан хүчээр дарамталж харьцах зэргийг

таашаадаггүй, ярилцаж, ойлголцож ойр байгаасай гэж хүсдэг)

удирдлагын арга барилд шүүмжлэлтэй ханддаг,

(Аливаа асуудлыг ухаж ойлгох, дүн шинжилгээ хийхдээ сайн, хэрвээ салбарын захирагч, аль нэг ахлах даргын удирах арга барил таалагдахгүй байгаа тохиолдолд бусад захирагч, даргын арга барилтай харьцуулан жишдэг, үүнээс болж захирагч даргадаа итгэх итгэл сулардаг)

бусад үеийнхэнтэй харьцуулахад хамгийн их сошиал хэрэглээтэй, цахим орчинд идэвхтэй байдаг залуучууд байна.

(Гар утас, цахим орчноос хамааралтай, гэр бүл, найз, нөхөд, эхнэр хүүхэдтэйгээ дүрст дуудлага хийх, ойр ойрхон ярихыг хүсдэг, үүнтэй холбоотойгоор нууцаар утас барих, захирагч дарга нарт баригдах, шийтгүүлэх зэрэг асуудлууд гардаг)

Хугацаат цэргийн албанд татагдан ирж буй залуусын давуу тал

- Магтаал, урамшуулал, дэмжлэгийн тусламжтайгаар даалгасан ажлыг хурдан гүйцэтгэдэг

Хугацаат цэргийн албанд татагдан ирж буй залуусын сул тал

- Анхаарал төвлөрүүлэх чадвар сул,

- Хүч, чадал, тэсвэр шаардсан ажлаас амархан няцах гэдэг,

- Аливаа зүйлийг хийхдээ цагт баригдалгүй дуртай цагтаа хийх, бие даасан, хараат бус байхыг эрмэлздэг,

- Технологиос хэт хамааралтай

Дүгнэлт, санал

Цаг үе хурдацтай хувьсан өөрчлөгдөхийн хэрээр Хил хамгаалах байгууллагад хугацаат цэргийн алба хаахаар татагдан ирж байгаа иргэд Z үеийн томоохон төлөөлөл байна. Тэдэнтэй ажиллах арга барил 2000-аад оны үеийнхтэй адил биш. Тэднийг хилчин болгон хүмүүжүүлэх хилчдээс маш их ур чадварыг шаардаж байна. Иймд яг одоогийн байдлаар цэргийн албанд татагдан ирж байгаа хамгийн ойр ажилладаг алба хаагчид маань тэдний сэтгэл зүйн онцлогыг сайн мэдэж байх нь чухал байна.

Иймд хамгийн түрүүнд тэдний сэтгэл зүйн онцлогийг сайтар судалж тэднийг сурган хүмүүжүүлэх, хилчин байлдагч болгон бэлтгэх сургалтдаа ашиглах нь чухал юм.

Мөн Z үеийн ХЦАХ-тай ажилласан туршлага, хилийн цэргийн дугаар ангийн ХЦАХ-тай хийсэн ганцаарчилсан болон бүлгийн ярилцлагын дүгнэлтээс үндэслэн дүгнэхэд Z үед төрч өссөн сэтгэл зүйч албан хаагч тэднийг маш сайн ойлгож зөвлөгөө өгдөг нь харагдсан. Иймд тухайн буюу Z үед төрж өссөн сэтгэл зүйчдийг ажиллуулах нь үр дүнгээ өгнө гэж дүгнэж байна.

Эх сурвалжийн жагсаалт:

- <https://www.buro247.mn/lifestyle/expert/z-eiynkhniy-talaar-bid-yuug-medekh-kheregtey-ve.html>
- <https://updown.mn/203693.html>
- <http://mongolcom.mn/read/14027>
- <https://unread.today/c/random-genz-entertainment>

АЮУЛГҮЙ БАЙДЛЫН УДИРДЛАГА УДИРДЛАГА

АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТУХАЙ ОЙЛГОЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

Б.Одбаатар.

ДХИС-ийн Удирдлагын академийн Цагдаагийн удирдлага, стратегийн тэнхимийн профессор, хууль зүйн доктор, цагдаагийн хурандаа

Товч агуулга: Энэхүү нийтлэлд аюулгүй байдлын тухай ойлголт, түүний мөн чанар, хамрах хүрээ, ач холбогдлын талаар авч үзэхийг зорилоо.

Түлхүүр үгс: Аюулгүй байдал, байгууллагын аюулгүй байдал, дотоод аюулгүй байдал, хувь хүний аюулгүй байдал.

Abstract: This article aims to discuss the concept of security, its nature, scope and importance.

Keywords: Security, organizational security, internal security, personal security.

Оршил

Аюулгүй байдал нь нэн эртний ойлголт бөгөөд хүн төрөлхтөн үүсэн хөгжсөн цагаасаа өөрийн аюулгүй байдалд санаа тавьсаар ирсэн. Дэлхий ертөнцөөс эхлээд бидний хүрээлэн байгаа орчин, улс гүрэн, байгууллага, хувь хүний оршин тогтнох эсэхийг шийдвэрлэх гол хүчин зүйл бол “аюулгүй байдал” тул түүнийг хэрхэн бий болгож хангаж байгаагаас улс гүрний тусгаар байдал, иргэдийн амьдралын баталгаа хамаарч байдаг. Аюулгүй байдлын тухай уламжлалт ойлголт нь бусад улс гүрнээс үзүүлэх аюул заналхийлэл, түүнд тулгуурласан түгшүүр байдаг бол орчин цагт материаллаг аюулгүй байдлыг нийгмийн аюулгүй байдлын сүлжээ болон глобалчлалтай холбон тайлбарлах болсон. Ийм ч учраас

аюулгүй байдал нь түүхийн цаг хугацааны явцад өргөжин тэлсээр олон шинжлэх ухаан, онолын мэдлэгийн огтлолцол дээр үүсч одоо “аюулгүй байдал судлал” бие даасан шинжлэх ухааны түвшинд хүрээд байна.

Эрх зүйн толь бичигт аюулгүй байдлыг “Тухайн улсад улс төр, эдийн засаг, нийгэмшлийн тогтвортой байдлыг тогтоон хангах, хуулийг чанд сахин биелүүлэх, эрх зүйн дэг журмыг хангуулах, олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх үндэс болсон улс төр, эдийн засаг, нийгэмшил, цэрэг, экологи, мэдээллийн болон бусад шинж чанартай аюул заналхийллээс бие хүн, нийгэм ба төрийн амин чухал ашиг сонирхол хамгаалагдсан байдал¹” гэж тодорхойлжээ.

¹ С.Нарангэрэл. Эрх зүйн эх толь бичиг. – Уб., 2007. 54 дэх тал.

Энэ бүхнээс товч дүгнэхэд “Аюулгүй байдал нь аливаа гадна, дотны сөрөг нөлөөллийн хүчин зүйлээс найдвартай, баталгаатай хамгаалагдаж, амар тайван оршин байх нөхцлийг цогц байдлаар хангасан байх ойлголт” гэж үзэж болох юм.

Түүхэн эх сурвалж, бүтээлд тусгагдсанаар “аюулгүй байдал” гэдэг ухагдахуун бүр XII зуун (1190 он)-ы үеэс хүний ойлголт, ухамсрын түвшинд, юуны урьд хүний оюун санааны амгалан тайван байдал, аливаа аюул заналаас ангид хамгаалагдсан байх тухай ойлголтод хамаардаг байсан байна.

Баруун европ дахинд XVII зууныг хүртэл ухагдахууны түвшинд төдийлэн яригдаж нэвтрээгүй бөгөөд харин XVII-XVIII зууны хооронд “дэлхийн чинээлэг аж амьдрал, түүний аюулгүй байдал” гэсэн ойлголтоор зонхилон хэрэглэгдэж байжээ.

Социалист тогтолцооны үед аюулгүй байдал гэдгийг зөвхөн цэрэг, арми, батлан хамгаалах хүчин чадалтай холбон ойлгож ирсэн ба түүхийн цаг хугацаанд 1990 оны ардчилсан хувьсгалын үрээр нийгмийн нэг тогтолцооноос нөгөө тогтолцоонд шилжин урьд мэдэхгүй байсан нийгмийн цоо шинэ харилцаанууд үүсч түүгээр ч зогсохгүй аюулгүй байдлын тухай ойлголт өргөн хүрээг хамрах болсон.

Орчин үед “бусад улс орны дотоод, гадаад аюул занал бүхнээс өөрийн орны хүн ам, хувь хүний эрх

ашиг, улс нийгмийнхээ бүрэлдэхүүн хэсэг хийгээд улс орны нийтлэг ашиг сонирхол бүхэлдээ ямар нэгэн аюул, заналгүй хамгаалагдсан бодит нөхцөл байдлыг аюулгүй байдал гэж ойлгох ёстой” гэж үзэж байна.

Аюулгүй байдал нэг талаасаа улс, нийгэм, иргэний аюулгүй байдлыг найдвартай хангах үүднээс хэрэгжүүлж буй арга хэмжээ, түүнд нийцсэн бодлого, хөтөлбөрийн цогц ойлголт бөгөөд аюулгүй байдлыг арилгах, саармагжуулах, ямар нэгэн өөр хөнөөлтэй үйл явц, нөхцөл байдлын улмаас үүдэлтэй хүн ам, нийгмийн эрэлт, хэрэглээ хоёрын зөрчлийг арилган саармагжуулах, цаашид аюул, хөнөөлт байдлаас үүсэх хор хохирлыг арилгахад чиглэгдсэн үйл ажиллагаа юм.

Аюулгүй байдал судлал буюу “секьюритологи” секуритэ – аюулгүй байдал гэсэн латин үг, логос – үг, сургаал гэсэн грек үгний нийлбэр буюу орчуулбал “аюулгүй байдлын шинжлэх ухаан” гэсэн агуулгыг илэрхийлнэ. Үүний зэрэгцээ “секьюрити” (*англ. security*) гэсэн үг аюулгүй байдлын агуулга бүхий хамгаалалт, бэхлэлт, найдвартай чанар, хамгаалах, нууцлалт, хангалт, бүрэн бүтэн байдал, хадгалах, найдвар, аюулгүй байдлын байгууллага, сөрөг тагнуул зэрэг олон утгыг илэрхийлдэг байна. Аюулгүй байдлын мөн чанарын талаарх ойлголтыг дараах байдлаар ангилан авч үзэж болох юм. Үүнд: